



2022 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН



БАТАРҮУ

НЭН ТҮРНИД
МОДЛИЙ БАЙДАЛ

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ОСОЛ 0

АГУУЛГА

Мэндчилгээ	4
Ерөнхий мэдээлэл	6
Үндсэн үйл ажиллагааны статистик	7
Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ	10
Алсын хараа, эрхэм зорилго	15
Бүтэц зохион байгуулалт	16
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	18
Хүний нөөц	23
Байгаль орчны хяналт, нөхөн сэргээлт	32
Хамтын ажиллагаа	39
Аудитын тайлан	42



МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, харилцагч байгууллагууд та бүхнийхээ амар мэндийг эрэн мэндчилье.

2022 он манай “Багануур” ХК-ийн уурхайчин хамт олны хувьд өндөр ачаалалтай жил байлаа. Хил гааль хаалттай, бараа материалын үнийн өсөлттэй, эдийн засаг, нийгмийн байдал хүнд байсан хэдий ч оны эхнээс сар бүрийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр жигд биелүүлэн ажиллалаа.

Мөн өнгөрсөн он байгаль цаг уурын хувьд хүндхэн жил байлаа. Зун нь бороо хур ихтэй, өвөл нь Багануур дүүрэгт 20-22 удаа цас орж, дунджаар 37 см зузаан цасан бүрхүүл тогтож, шөнөдөө -37...-43 хэм хүртэл хүйтэрсэн, сүүлийн 30 жилд байгаагүй хүйтэн өвөл болсон.

Гэсэн ч бид Монгол улсын эрчим хүчний салбарын өмнө хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж, нийт 16.1 сая/м³ хөрс хуулж, 27.0 сая/м³ уулын цулын ажил хийж, 4.35 сая. тн нүүрс олборлон борлуулснаар үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 101-108 хувиар биелүүлсэн нь уурхайчдын

маань ажлын амжилт, хамтын хөдөлмөрийн үр дүн юм.

Түүнчлэн 4.35 сая.тн нүүрс олборлон борлуулсан нь түүхэн дэх хамгийн өндөр үзүүлэлт болсон. 2022-2023 оны өвлийн бэлтгэл ажлыг хангахад “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дэмжлэгтэйгээр “Эрдэнэс Таван толгой” ХК-аас урт хугацаат зээл авсан нь өвлийн ид ачааллыг амжилттай даван туулахад их тус дэм боллоо.

Компанийн орлогын төлөвлөгөөг 102.9 хувь, зардлын төлөвлөгөөг 98.9 хувь, ашигт ажиллагааны түвшин 83.4 хувь буюу төлөвлөсөн алдагдлыг 6.8 тэрбум төгрөгөөр бууруулан үйлдвэрлэлийн осол авааргүй ажиллалаа.

Бид үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаанаас гадна бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, нийгмийн хариуцлага, нөхөн сэргээлт зэрэг олон чиглэлээр томоохон ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. Тухайлбал:

- Уурхайг ашиглалтанд хүлээн авах улсын комиссын актыг шинэчлүүлсэн, ингэснээр жилд 10 сая.тн нүүрс олборлон борлуулах төслийн хүчин чадлаар цаашид

- үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжтой болсон;
- Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдалын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартын магадлан аудитын дүгнэлтээр стандартын баталгаажуулалтын гэрчилгээг үргэлжлүүлэн хадгалах болсон.
 - Дулааны цахилгаан станцуудад нийлүүлэх нүүрсний үнийг 29.3 хувиар нэмэгдүүлсэн;
 - Сүүлийн жилүүдэд огт хийгдээгүй байсан Технологийн автомашинуудын үндсэн эд ангийн агрегат засварыг хийсэн.
 - 2019 онд эхлүүлсэн “110/6кВ-ын Уулындэдстанц”-г нүүлгэн, шинээр барих төслийг 2022 оны 7-р сард дуусган, ашиглалтанд оруулсан;
 - Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, 2030 он хүртэл “Нэг сая мод” тарьж ургуулахаар төлөвлөн, 2022 онд мод үржүүлгийн талбай байгуулж 100000 модны үрсэлгээ хийсэн.
 - Цалин хөлс, урамшууллын системийг өөрчилж гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний системийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн зэрэг олон ажил дурьдаж болохоор байна.

“Төрийн хэмнэлтийн тухай” хууль батлагдан гарсантай холбогдуулан 0.66 тэрбум төгрөг, хөрс хуулалтын хэмжээг өмнөх жилүүдээс 4.4 сая. м³-ээр бууруулж 10.7 тэрбум төгрөг, компани дотооддоо хэмнэлтийн ажил зохион байгуулж 1.9 тэрбум төгрөгийг

хэмнэснээс гадна, худалдан авалтын ажлыг оновчилсны дүнд төлөвлөгөөг 9.0 хувиар буюу 8.8 тэрбум төгрөгөөр хэмнэн ажиллалаа.

2023 онд Багануурын уурхайн 45 жилийн ой тохионо. Бид энэхүү ойн жилдээ 4.5 сая тонн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Түүнчлэн Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг найдвартай хангах, техникийн шинэчлэл хийх, нэмүү өртөг шингээсэн, компанийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг маш олон том ажил биднийг хүлээж байна.

“Багануур” ХК-ийн уурхайчин хамт олон бидэнтэй хамтран ажилласан Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, “Эрдэнэс Монгол” ХХК, төр захиргааны байгууллага, харилцагч байгууллагууд та бүхэндээ талархал илэрхийлье.

Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч



Д.ТҮВШИНЖАРГАЛ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1978 онд
байгуулагдсан



1123
ажилтантай



**ТЭЭВЭРТЭЙ
ТЭЭВЭРГҮЙ**
хосолсон
ашиглалтын
систем




75.00% "Эрдэнэс
Монгол" ХХК
21.06% Монголиан
коал корпорейшн
3.94% Жижиг



НӨӨЦ
778,0
сая.тн




ЖИЛИЙН ХУЧИН
ЧАДАЛ
4,0 сая.тн




НҮҮРСНИЙ
ИЛЧЛЭГИЙН
СТАНДАРТ
3360 ккал/кг

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК


ХӨРС ХУУЛАЛТ /МЯН.МЗ/




ХӨРС ХУУЛАЛТЫН КОЭФФИЦИЕНТ




НҮҮРС БОРЛУУЛАЛТ /МЯН.ТН/




НҮҮРСНИЙ ДУНДАЖ ИЛЧЛЭГ /ККАЛ.КГ/




ТЭСЭЛСЭН УУЛЫН ЦУЛ /МЯН.МЗ/




ӨРӨМДЛӨГИЙН АЖИЛ /МЯН.МЕТР/




БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ /мян.төг/




ТАТВАР ХУРААМЖ /тэрбум.төг/




УС ШҮҮРҮҮЛЭЛТ /мян.м3/




АЮУЛЫГ МЭДЭЭЛЖ АРИЛГАЛТ



ТЕХНИК АШИГЛАЛТЫН КОЭФФИЦИЕНТ




СУРГАЛТАД ХАМРАГДСАН АЖИЛТНЫ ТОО



БАГАНУУР ХК

УЛС ОРНУУДЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНЭ

Эрчим хүчний үнэ тарифыг харьцуулан харвал Германд гэхэд **1 кВт.цаг** нь **23.1** ам.цент, Японд **19.3**, БНСУ-д **8.6**, урд хөршид **10.3**, хойд хөршид **9.3** ам.цент байна.




**СТАНЦАД НИЙЛҮҮЛСЭН
НҮҮРСНИЙ ГҮЙЦЭТГЭЛ**

№	Станцууд	Мян.тн
1	ДЦС-4 ТӨХК	2127,0
2	ДЦС-3 ТӨХК	1413,8
3	ДЦС-2 ТӨХК	243,3
4	ДДЦС ТӨХК	144,9
5	ЭДЦС ТӨХК	41,8

БАГАНУУР ХК

**МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ
НҮҮРСНИЙ 60 ХУВИЙГ ХАНГАДАГ**



ЭРЧИМ ХҮЧНИЙ НҮҮРСНИЙ ҮНЭ



43,3₮



150₮

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Багануурын уурхай нь улс орныхоо төвийн бүсийг гал алдуулахгүй эрчим хүчний нүүрсээр тасралтгүй хангаж, осол зөрчилгүй, хөгжиж, өөрчлөгдөж, урагш алхаж ажиллах үндсэн үүргээ биелүүлэн ажилласан.

Өнгөрсөн онд уурхайчин хамт олон маань үйлдвэрийн үндсэн үзүүлэлт болох нүүрс гаргалт, борлуулалтын төлөвлөгөө 101.4 хувь, хөрс хуулалтын төлөвлөгөө 104.4 хувь, нийт уулын цулын ажлыг 108 хувьтай биелүүлэн ажиллалаа.

Мөн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад шаардлагатай 23.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг “Эрдэнэс Монгол” нэгдлийн нүүрс, эрчим хүчний группийн хүрээнд шийдвэрлэн ажиллалаа.

Эрчим хүчний салбар нь улс орны, аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, түрүүлж хөгжүүлэх шаардлагатай эдийн засгийн суурь салбар учраас төрөөс эрчим хүчний талаар ихээхэн анхаарч ажиллаж байна.

Ирэх онд Монгол Улсын эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах зорилгын хүрээнд уурхайн техник шинэчлэлийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг

шийдвэрлүүлэх, компанийн дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, компанийн хүний нөөцийн бодлого, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг нэмэгдүүлэх зэрэг томоохон ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Ингээд 2022 онд бидэнтэй хамтран ажилласан харилцагч байгууллага, иргэд та бүхэндээ баярлалаа.

“Багануур” ХК-ийн ТУЗ-ийн дарга



Б.ЦЭВЭГЖАВ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ЦЭВЭГЖАВ

Нэгдсэн удирдлага, стратегийн хэлтсийн дарга
“Эрдэнэс Монгол” ХХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Д.БАЛЖИННЯМ

Захиргаа хүний нөөцийн удирдлагын газрын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Г.НАНДИНЖАРГАЛ

Төрийн нарийн бичгийн дарга,
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Г.ЗОЛБОО

Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга,
Сангийн яам

Д.ДАВААСҮРЭН

Эрчим хүч, түлшний бодлогын хэрэгжилтийн газрын Түлшний хангамжийн хэлтсийн дарга,
Эрчим хүчний яам

М.ОТГОНБАЯР

“Монголиан Нейшнл Коул Корпорейшн” ХХК”-ийн төлөөлөл

Д.ЧИНБАТ

“Монголиан Нейшнл Коул Корпорейшн” ХХК-ийн төлөөлөл

Б. ОЧБАДРАХ

Хараат бус гишүүн, “Монгол Эрмэлзэл” ТББ-ын Тэргүүн

Д.ОТГОНБАТ

Хараат бус гишүүн “Өмгөөллийн Дэнс Легал” ХХН-ийн захирал

Б.ОСОРГАРАВ

Хараат бус гишүүн, “Грант Торнтон аудит” ХХК-ийн Ерөнхий захирал

С.ЭНХТАЙВАН

Хараат бус гишүүн,
“Монголиан транс ложистик” компанийн Хуулийн хэлтсийн дарга



A large-scale open-pit mine with a yellow dump truck in the foreground. The background shows a massive, terraced excavation site with a yellow excavator on the left. The foreground features a yellow dump truck with '700' and 'MOHAF' markings, driving on a dark, rocky road. The overall scene is a vast, industrial mining operation.

2022

4.4
САЯ.ТН
НҮҮРС

КОМПАНИЙН ТУХАЙ

"Багануур" ХК нь анх 1978 онд 200.0 мян.тн нүүрс олборлох хүчин чадалтай "Багануурын нүүрсний түр уурхай" нэртэйгээр байгуулагдаж, эдүүгээ 45 дахь жилдээ ажиллаж байна. Монгол улсын эрчим хүчний нүүрсний хэрэгцээний 60 хувь, төвийн бүсийн эрчим хүчний нүүрсний хэрэгцээний 70 хувийг дангаараа хангадаг стратегийн ач холбогдол бүхий нүүрсний ил уурхай юм.

Нүүрсний орд нь зүүн хойноос баруун урагш чиглэсэн суналын дагуу уртаараа 12 км, өргөнөөрөө 4-5 км талбай эзэлж мульд маягаар тогтсон үндсэн 3 давхаргаас бүрдэнэ. Багануурын нүүрс нь эрчим хүчний зориулалттай Б2 маркийн нүүрсэнд хамаарна. Нүүрсний үнслэг нь 12-17 хувь, чийглэг нь 28-33 хувь, хүхрийн агуулга нь 0.4 хувь, дулаан гаргах илчлэг нь 3200-3600 ккал/кг.

1978 онд баталсан тооцоогоор нүүрсний нөөц 599.0 сая.тн 1988 онд нарийвчилсан хайгуул хийж ордын баялаг нөөцийг 708.2 сая.тн болгосон. 2014-2015 онд Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар Багануурын нүүрсний ордын гүйцээх хайгуулын ажил хийгдэж балансын НӨӨЦИЙГ 280.0 сая.тн-оор нэмэгдүүлж Олон улсын JORC стандартаар үнэлэгдсэн нийт 812.0 сая.тн баталгаат нүүрсний нөөцтэй болсон.




АЛСЫН ХАРАА



Монгол Улсын нүүрсний салбарын чиг хандлагыг тодорхойлогч байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО



Тогтвортой хөгжлийг хангасан, мэдлэг инновацид суурилсан үндэсний тэргүүлэгч компани болно.

ҮНЭТ ЗҮЙЛ

АЮУЛГҮЙ БАЙДАЛ



Бид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг нэн тэргүүнд тавьдаг.

САНААЧЛАГЧ, БҮТЭЭЛЧ, СУРАЛЦАГЧ



Бид мэргэжилдээ хүндэтгэлтэй хандан, санаачлагатай байж, шинэ шийдэл ажлын шинэ арга замыг бүтээлчээр хөгжүүлж, мэргэжлийн өндөр түвшинд үйл ажиллагаа явуулахын тулд мэдлэг ур чадвараа байнга дээшлүүлдэг.

ШУДАРГА ҮНЭНЧ



Бид зөв зүйлийг хийж, шударга ил тод байдаг. Өөртөө болон бусдад зарчимч байдлаар хандаж, шударга бус байдалтай үл эвлэрнэ.

ХАРИУЦЛАГА



Бид үүрэг хариуцлагаа ухамсарлаж хийж буй үйлдэл хэлсэн үгэндээ эзэн болдог.


БАГИЙН АЖИЛЛАГАА, ХАМТЫН ХҮЧ



Бид харилцан итгэлцэл хүндлэлийг бий болгон хүн бүр багийн нэг хэсэг болж үр дүнтэй хамтран ажилладаг.

БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 22 тоот тогтоол, Гүйцэтгэх захирлын 2022 оны А/10 дугаартай тушаалаар компанийн орон тоог баталж 7 хэлтэс, 3 алба, 9 хэсгийн нийт 1123 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.



КОМПАНИЙН УДИРДЛАГА

Д.ТҮВШИНЖАРГАЛ

Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч

Н.БАЗАРСҮРЭН

Үйлдвэрлэл, технологи эрхэлсэн дэд захирал

А.ЭНХБОЛД

Техникийн бодлого эрхэлсэн дэд захирал

У.ЦОЛМОНГЭРЭЛ

Хүний хөгжил, судалгаа эрхэлсэн дэд захирал

Г.ГАНСҮХ

Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал

Ч.НАРАНБАТ

Технологийн бодлогын хэлтсийн дарга

Х.ХАШБАТ

Техникийн бодлогын хэлтсийн дарга

Ч.АРИУНБААТАР

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга

Б.БАТБОЛД

Захиргаа, хүний нөөц удирдлагын хэлтсийн дарга

Ж.БОЛД-ЭРДЭНЭ

Санхүү, эдийн засаг бодлогын хэлтсийн дарга

Д.ХИШИГДЭМБЭРЭЛ

Худалдаа, хангамж хариуцсан хэлтсийн дарга

Ц.ЭНХБАТ

Судалгаа хөгжлийн хэлтсийн дарга

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

БОДЛОГО БАРИМТЛАХ ЗАРЧИМ

“Багануур” ХК нь ХАБЭА-н хуулийн заалтыг хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг аюулгүй явуулах, ажилтнаа хамгаалах зорилгоор ХАБЭА-н удирдлагын тогтолцооны Олон Улсын стандартын хүрээнд ХАБЭА-н бодлогыг боловсруулан хэрэгжүүлж байна.



ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ

100%

ҮЙЛ АЖИЛЛАГАА

2022 онд 6 зорилтын хүрээнд 27 заалттай төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажилласан, төлөвлөгөөний биелэлт 100 хувь.

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 Олон Улсын стандартыг хэрэгжүүлэгч байгууллагаар 2021 онд батламжлагдсан. Стандарт хэрэгжүүлэгч байгууллага нь жил бүр стандартын хэрэгжилтээ шалгуулж, баталгаажуулж байх юм. Тиймээс дотооддоо гүйцэтгэлийн хэмжилт мониторинг, дотоод аудитыг тогтсон хугацаанд хийж, илэрсэн үл тохирлуудыг Гүйцэтгэх удирдлагын хэмжээнд танилцуулан шийдвэр гаргуулах удирдлагын дүн шинжилгээний хурлыг зохион байгуулдаг. Үүний дараа Олон Улсын баталгаажуулалтын байгууллагаар магадлан аудит хийлгэж магадлан аудитын дүгнэлтийг үндэслэн стандартын гэрчилгээг хадгалаж үлдэх эсэх нь шийдэгддэг.

2022 оны 6 дугаар сард гүйцэтгэлийн хэмжилт мониторинг, дотоод аудитыг хийсэн бол 8-р сард Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны удирдлагын дүн шинжилгээний хурлыг зохион байгуулж 9 дүгээр сард магадлан аудит хийгдсэн. Олон Улсын баталгаажуулалтын “Монсертф” ХХК-ийн аудитын багийн дүгнэлтийг баталгаажуулалтын зөвлөлийн хурал дэмжсэнээр “Багануур” ХК Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартын гэрчилгээг хадгалж үлдсэн.

Мөн компанийн хэмжээнд 2022 онд эрсдлийн түвшин 0.5 хувиар буурсан үзүүлэлт гарсан.

2022 ОНД ЭРСДЛИЙН ТҮВШИН


0.5% ↓

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ

ХАБЭА-н сургалтыг Хөдөлмөрийн сайдын 2019 оны А/370 тоот тушаалд заасан үлгэрчилсэн хөтөлбөрийн дагуу үндсэн 9, дэд 29 сэдвийн хүрээнд 7 цагийн багтаамжтай хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан 2 удаагийн сургалт зохион байгуулсан.



ХАБЭА-н сургалтын хамрагдалт



ХАБЭА-н шалгалтын хамрагдалт, чанар




ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ


Ажилтнууд ажил эхлэхийн өмнө ажлын байр, орчин, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаанд үзлэг хийж илэрсэн зөрчлийг аюулыг мэдээлэх хуудас, аппликейшн болон утсаар мэдээлэх, мэдээллээр ирсэн зөрчлийг нэн даруй арилгах үүргийг ХАБЭА-н хэлтсээс холбогдох албан тушаалтанд өгч, биелэлтийг 7 хоног бүрийн үйлдвэрийн шуурхай зөвлөгөөнд танилцуулан ажилладаг.




Мэдээлсэн аюул эрсдэлийн тоо, арилгалтын хувь




Осолд дөхсөн тохиолдол




Ээлжит үзлэгээр илэрсэн зөрчлийн тоо



Ээлжит бус үзлэгээр илэрсэн зөрчлийн тоо



Үйлдвэрлэлийн осол





ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУЛГУУР
УУРХАЙ



ХҮНИЙ НӨӨЦ

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО



1. ЭРҮҮЛ УУРХАЙЧИН

Өв тэгш бие бялдарын хөгжилтэй Эрүүл зөв зохистой хооллолттой Амьдралын зөв дадал, хэвшилтэй.



3. ЗӨВ ҮЗЭЛ ХАНДЛАГАТАЙ УУРХАЙЧИН

Үнэт зүйлтэй
Нийгмийн зөв төлөвшилтэй



2. БОЛОВСРОЛТОЙ УУРХАЙЧИН

Ажил мэргэжлийн ур чадвартай, мэдлэгтэй мэргэжилдээ мэргэшсэн уурхайчин.
Нийгэм эдийн засгийн боловсролтой. Иргэний боловсролтой.



4. ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХИТАЙ УУРХАЙЧИН

Бүтээмжид суурилсан хөдөлмөрийн хөлс, цалин урамшууллын оновчтой тогтолцоотой.
Санхүүгийн төлөвлөлт үр ашигтай зөв зарцуулалттай.

ХҮНИЙ НӨӨЦИЙН СТАТИСТИК



30% Дээд
10% Тусгай дунд
54% Бүрэн дунд
6% Бүрэн бус дунд



18-23 насны 2%
24-39 насны 51%
40-55 насны 42%
56-60 насны 5%



86%

14%

Эмэгтэй ажилтнуудын 9% нь удирдах түвшинд ажилладаг.



Ажилласан жил /хувиар/
0-5 жил 27%
6-15 жил 42%
16-с дээш жил 31%

1. ЭРҮҮЛ УУРХАЙЧИН

Ажилтнууд болон тэдний гэр бүлийн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Сэтгэл судлалын үндэсний төв, Багануур дүүргийн ЭМТөв, хоол зүйчтэй хамтран сургалт, мэдээллийг хүргэн, олон нийтийн болон нөлөөллийн ажил, арга хэмжээг зохион байгуулсан.

МШӨ-өөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Багануур Сувилал” болон бусад улсын чанартай рашаан сувилалд нийт 224 ажилтныг сувилуулсан.

“Уурхайчин” зоогийн газрын хоолны цэсийг өөрчилснөөр ногоон хоол /эрүүл мэндэд тустай/-ны хэрэглээ өмнөх оноос 5 хувиар нэмэгдэж, улаан хоол /эрүүл мэндэд сайнгүй/-ны хэрэглээ 14%-иар буурсан байна.


“Уурхайчин” спорт цогцолбороор нийт 4119 уурхайчин үйлчлүүлсэн ба спорт цогцолборын дэргэдэх хөлбөмбөг, хоккей, гар бөмбөг, сагсан бөмбөг, дартс, пауэрлифтинг, ширээний теннис, үндэсний бөх, сур харваа, шагайн харваа гэх мэт 10 гаруй клубуудад давхардсан тоогоор нийт уурхайчдын 31,4% тогтмол хичээллэж байна.

2022 онд “Уурхайчин” спорт цогцолбор 26 удаагийн спортын арга хэмжээ зохион байгуулсан.” спорт цогцолбор 26 удаагийн спортын арга хэмжээ зохион байгуулсан.


2. БОЛОВСРОЛТОЙ УУРХАЙЧИН

2022 онд Гүйцэтгэх захирлын А/214 тоот тушаалаар “Сургалт хөгжлийн журам”-ыг батлуулан сургалтын төлөвлөгөөний дагуу ажилтнуудад ерөнхий мэдлэг олгох, Инженер техникийн ажилтнууд болон ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, аюулгүй ажиллагааны тусгай эрхийн сургалтуудыг зохион байгуулан ажилласан.

СУРГАЛТЫН ЗАРДАЛ /САЯ.ТӨГ/



СУРГАЛТАД ХАМРАГДСАН АЖИЛТНУУДЫН ТОО



Шинэ ажилтны сургалт:

2021-2022 онд шинээр ажилд орсон 72 ажилтанд сургалтын хөтөлбөр боловсруулан уурхайн үйл ажиллагаатай танилцуулах, сургалтын байгууллагатай хамтран Хувь хүний хөгжлийн сургалтыг зохион байгуулсан. Удирдлага, ИТА-уудын ур чадвар дээшлүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр дараах сургалтуудыг зохион байгуулсан ба нийт 264 ажилтан хамрагдсан байна.

1. Авлига, Ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан бэлтгэх
3. Төрийн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх
4. Дотоод аудитор, Хүний нөөц, Санхүү хөрөнгө оруулалт, мэргэшсэн нягтлан бодогч
5. Уул уурхай, цахилгаан тоног төхөөрөмж
6. Мэдээллийн болон Кибер аюулгүй байдлын тухай, Хяналт удирдлагын систем /SCADA-2/

Ажилтнуудын мэргэжлийн сургалт:

Экскаваторын машинч, туслах машинч, өрмийн машинч, туслах машинч, гагнуурчин, мастер, механик, цахилгаанчид гэсэн нийт 299 ажилтанд Цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцан ажиллах аюулгүй ажиллагааны эрхийн сургалт, Зуухны машинчийн Чадамжийн гэрчилгээ олгох сургалтыг 14 ажилтанд, тэсэлгээчний эрхийн сургалтанд 21 ажилтан, YAMX-ийн жолооч нарт мэргэшсэн жолоочийн болон аюултай ачаа тээвэрлэх эрхийн сургалтанд 5 ажилтан, нийт 339

ажилтанд сургалт зохион байгуулсан.

Эрсдэлтэй ажлын байрны сургалт:

Мэргэжлийн сургалтын байгууллагатай хамтран Ачаа өргөх тээвэрлэх, тоног төхөөрөмжтэй харьцан ажиллах Аюулгүй ажиллагаа хариуцагч, Краны оператор /цахилгаан таль/, Оосорлогч дохиочин, даралтат савны бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаа хариуцагч, Даралтат сав шугам хоолойтой харьцаж ажиллах эрхийн сургалтыг зохион байгуулсан ба нийт 407 ажилтан хамрагдсан байна.

Ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх:

Компанийн “Мэргэжлийн зэрэг нэмэх болон ур чадварын нэмэгдэл олгох журам”-ын дагуу Экскаваторын машинч-10, Экскаваторын цахилгаанчин-6, Уулын тоног төхөөрөмжийн засварчин-7, Токарьчин, фрейзерчин-3, Гагнуурчин-4, нийт 30 ажилтны мэргэжлийн зэргийг ахиулсан.



3. 3ӨВ ҮЗЭЛ ХАНДЛАГАТАЙ УУРХАЙЧИН

МУ-ын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан **“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН, АРХИГҮЙ МОНГОЛ”** үндэсний хөдөлгөөнд нэгдэж нэг сарын аян өрнүүлсэн.

Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулж буй **“ААЖУУ ЯВБАЛ АЯНДАА ХҮРНЭ ДЭЭ”** аянд нэгдэж 1 сарын хугацаатай нөлөөллийн ажил зохион байгуулсан.




4. ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХИТАЙ

Цалин хөлс, урамшууллын системийг өөрчилж гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний тогтолцоог бий болгохоор зорин ажиллаж байна.

Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хорооны хооронд байгуулсан Хамтын гэрээний дагуу ажилтнуудад шагнал урамшуулал, нэмэгдэл, хөнгөлөлт тусламж, тэтгэмжийг олгож байна.

Үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хороотой байгуулсан хамтын гэрээний биелэлт



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

“Бидний дэм малчдад” аяны хүрээнд дүүргийн болон хил залгаа сумдын мал бүхий иргэдэд 500 ширхэг тусламжийн багцыг хандивлалаа.



Дүүргийн 5 хорооны зорилтот бүлгийн 293 өрхөд нүүрс хандивлалаа.



ЦССҮТөвтэй хамтран “Миний бэлэглэсэн цус-3 хүнд амьдрал бэлэглэнэ” аяныг өрнүүлж, 100 гаруй уурхайчин энэхүү аянд нэгдсэн.



Төв аймгийн хойд болон зүүн талын сумдаар их хэмжээний цас орж, цасан шуурга шуурч, байгалийн онц аюулт үзэгдэл болсоны улмаас Улаанбаатраас зүүн аймгуудыг чиглэн явсан зорчигч тээврийн 3 автобус Багануур дүүрэгт саатсан. Эдгээр автобуснуудад зорчиж байсан 70 иргэнийг Уурхайчин спорт цогцолборын зааланд буудаллуулж, үйлдвэрийн эмч нар анхан шатны эрүүл мэндийн үзлэг хийсэн.



2022 ОНЫ АМЖИЛТ

ТОП-100 аж ахуйн нэгжийн 34-т эрэмбэлэгдлээ.

Бүгд Найрамдах Улс тунхагласны 98 жилийн ой, Их эзэн Чингис хааны мэндэлсний 860 жилийн ой, Уул уурхайн салбарын 100 жилийн ой, "Монгол бахархлын өдөр"-ийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх зарлиг гаргаж "Багануур" ХК-ийн ахмад уурхайчин, экскваторын машинч, Гавъяат уурхайчин Гэндэнжавын Отгонпүрэвт Монгол улсын Хөдөлмөрийн баатар цол олгож Хөдөлмөрийн баатрын "Алтан соёмбо" тэмдэг, Сүхбаатарын одонгоор шагналаа.

Монгол улсын **"Аж үйлдвэрийн гавьяат ажилтан"** цол тэмдгээр ахмад уурхайчин Рэнцэнгийн Сундуй шагнууллаа.

Монгол улсын **"Гавъяат уурхайчин"** цол тэмдгээр ахмад уурхайчин Вандуйн Хашхүү шагнууллаа.

Монгол улсад Уул уурхай, Эрчим хүчний салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан Багануур ХК-нд тасралтгүй 25 болон түүнээс дээш жил үр бүтээлтэй ажилласан 220 ажилтанг салбарын 100 жилийн ойн медалиар шагнасан. 2022 онд уул уурхайн , эрчим хүчний салбарын шагналаар 103 ажилтан шагнагдлаа.



СПОРТЫН ТЭМЦЭЭН УРАЛДААН



Монгол улсад орчин цагийн уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн нэрэмжит Уурхайчдын спортын их наадамд 33 компанийн 1500 гаруй тамирчид спортын 5 төрлөөр оролцож хурд хүч, авъяас чадвар, ур ухаанаа сорин өрсөлдсөнөөс нийлбэр дүнгээр Багануур ХК-ийн баг Хүрэл медаль хүртсэн.



Багануур дүүргийн Засаг даргын нэрэмжит “ХӨДӨЛГӨӨН ЭРҮҮЛ МЭНД” сэдэвт биеийн тамир, спортын VIII их наадамд Багануур ХК-аас давхардсан тоогоор 139 тамирчин оролцож, 70 алт, 15 мөнгө, 8 хүрэл нийт 93 медаль авснаар нийлбэр дүнгээр тэргүүлж Шилжин явах цомын эзэд боллоо.

Хөл бөмбөгийн шигшээ багийн тамирчид 2022 онд таван тэмцээнд амжилттай оролцож 3 алт, 1 хүрэл медаль хүртсэн.



Пауэрлифтингийн тамирчид 2022 онд Азийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож мөнгөн медаль, Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож 2 алт, 1 мөнгөн медаль хүртсэн.



Дартсын шигшээ багийн тамирчид Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож 1 хүрэл медаль хүртсэн.



Үндэсний сурын тамирчид Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож, алтан медаль хүртсэн.






1.000.000
МОН



БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

Уул уурхайн салбарт 1999 онд ХАМГИЙН АНХ УДАА нөхөн сэргээх ажлыг эхлүүлсэн бөгөөд, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах, байгаль орчныг хамгаалах, дүйцүүлэн хамгаалал, нийгмийн хариуцлагын хүрээнд нэлээдгүй ажлуудыг хийгээд байна.


Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт




АГААРЫН ЧАНАР

NO₂, SO₂ Агаар дахь бохирдуулагч бодис /азотын давхар исэл NO₂, хүхрийн давхар исэл SO₂/-ын шинжилгээг БОХЗТЛ-оор улирал бүр хийлгэсэн. Шинжилгээгээр агаарын бохирдлын хэмжээ стандартаас хэтрээгүй байна.

Агаар бохирдуулагч бодис SO₂ /хүхрийн давхар исэл/-ын хэмжээ мг/м³




Агаар бохирдуулагч бодис NO₂ /азотын давхар исэл/-ын хэмжээ мг/м³



ТООСЖИЛТ

Тоосжилтийн хэмжилтийг 6 цэгт 2 сар тутамд Dust trak 85-20 загварын багаж ашиглан 24 цагийн турш хийж байна.

ОРЧНЫ БОХИРДОЛ



Орчны тоосжилтийг агаарын чанарын индексээр үнэлэхэд: Уул-1 хэсэгт 2 удаа, Уул-2 хэсэгт 1 удаа, дүүргийн төв хэсэгт 1 удаа, гэр хорооллын хэсэгт 2 удаа стандартаас хэтэрч бага зэргийн бохирдолтой, бусад цэгүүдэд стандарт түвшинд байна.

ТООСЖИЛТЫГ БУУРУУЛАХ

Агаар дахь тоосжилтыг бууруулах гол ажил бол зам засвар, зам усалгаа юм.

2022 ОНЫ ЗАМ ЗАСВАР



2022 ОНЫ ЗАМ УСАЛГАА



УС ШҮҮРҮҮЛЭЛТ, УСНЫ ЧАНАР

Багануур ХК нь 2022 онд 5.3сая.м³ усыг шавхан зайлуулж, усны төлбөрт 734.0 сая төгрөг төлсөн байна. Үүнээс Багануурын дулааны станцад, нүүрсний гал дарах, замын тоосжилт дарах, мод бутны усалгаа, гол нуурыг нөхөн сэргээх, тэжээхэд зарцуулж байна.

Гол, нуур тэжээсэн усны хэмжээ м³



Усны дээжийг тогтмол авч, Геологийн төв лаборатори болон БОХЗТЛ-д тус тус шинжилгээ хийлгэсэн.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хугацаа ба давтамж	Нийт хэмжилтийн тоо
1	Гадаргын ус - Хими - Хүнд металл	Дулааны улиралд	8
2	Багагүн нуур - Түвшин - Талбай	3 удаа	2
3	Гүний ус - Хими - Хүнд металл	Улирал бүр	25
4	Гүний ус - Түвшин	Сар бүр	12 удаа

ХӨРСӨН БҮРХЭВЧ

2022 онд Уулын 1-р хэсэгт 49.6мян.м³, Уулын 2-р хэсэгт 25.0 мян.м³ нийт 74.6мян.м³ шимт хөрсийг хуулж 19.4мян.м³ хөрсийг ачиж агуулахад буулгасан.

Цэгүүдэд байрлуулсан бохир хөрс цуглуулах савны ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж, бохир хөрсийг хөрс саармагжуулах талбайд цуглуулан саармагжуулсан.

Хөрсний агрохимийн үзүүлэлтийг дулааны улиралд нэг удаа 13 цэгээс дээж авч БОХЗТЛ-иор шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээгээр уурхайн шимт хөрсний агуулахад хадгалагдаж байгаа шимт хөрсний ялзмагийн агууламжийн хувь 0,10-0,59 хооронд байна.

Хөрсөн дэх нефьтийн агууламжийг 3 удаа, хүнд металлын үзүүлэлтийг дулааны улиралд нэг удаа 7 цэгийн дээжинд шинжилгээ хийлгэхэд стандартаас хэтрээгүй.




УРГАМАЛ БА АМЬТАН

Ургамлын болон амьтны ажиглалт судалгааг тогтмол жил бүр хийж байна.

ЦАЦРАГ

Гадаад орчны гамма цацрагийн тунгийн чадал уурхайн нүүрсний мөргөцгүүдэд цагт 0,05-0,13мкЗв байгаа нь байгалийн цацрагийн ердийн түвшинд байна.

Цацраг



ХОГ ХАЯГДАЛ

2022 онд хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр олон талт ажлыг хийсэн. Тухайлбал:

Дахиварт хуванцар 99.5 кг, Цаас 206 кг, Кардонон цаас 26 кг-ыг тус тус тушаасан.



Хадгалагдаж байгаа хог хаягдлаас дахин ашиглах боломжтой 35 нэр төрлийн 7853 нэгж хог хаягдлыг дахин ашигласан.

Дахин ашигласан хог хаягдал

Хэм/н	2021	2022
Төрөл	37	35
Нэгж	32832	7853

Аюултай хог хаягдал болох батерейны хаягдал авах савыг бүх ажилтнуудын орох, гарах хэсэгт байрлуулсан.



Компаний нийт ажилтнуудад “Хог хаягдлын талаарх сургалт”-ыг 4-р сард зохион байгуулсан.



НӨХӨН СЭРГЭЭЛТ

2022 онд Уулын 1-р хэсэгт дотоод овоолгод нийтдээ 4,6 сая.м³ хөрсөөр нөхөн дүүргэлт хийлээ.

Уулын ажлын онцлогоос хамааран уулын ажлын эцсийн хүрээ хязгаарын дагуу овоолгууд хэлбэржээгүй, биологийн нөхөн сэргээлт хийх талбай бэлэн бус тул мод тарих ажлыг түлхүү хийж байна.

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛ

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын хуучин Засаг даргын тамгын газарт Байгаль орчин, Аялал жуулчлалын мэдээлэл судалгааны төв байгуулан тохижуулсан.




”НЭГ САЯ МОД”


“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД **”БАГАНУУР”** ХК НЭГДЭЖ 2030 ОН ХҮРТЭЛ **“НЭГ САЯ МОД”** ТАРИНА.

“Багануур” ХК нь 2022-2024 онд жил бүр 10.000 ширхэг мод бут буюу нийт 40.000 ширхэг суулгацыг худалдан авч тарихаар төлөвлөсөн. 2026-2030 онд тарих 960.000 ширхэг модны тарьц, суулгацыг мод үржүүлгийн газартаа бойжуулж, тарилтанд шаардлагатай үрсэлгээгээ өөрсдөө хангана.

Нийт тарих модны тоо /ширхэг/



2026 он хүртэл нийт 960.000 ширхэг суулгац бойжуулна.



2022 онд компанийн мод үржүүлгийн газрыг шинээр байгуулан ажиллаж байна. Үүнд:

- Хүлэмжийн хэсэг
- Ил талбайн үржүүлэг
- Ажахуйн хэсэг

Үрийн талбайд хаврын тарилтаар:

- Улиас - 5800ш/модлог мөчрөөр/
- Бургас - 2000ш/модлог мөчрөөр/
- Хайлаас – 400м² талбайд/үрээр/
- Шар хуайс, Улиангар, Агч – 100м² талбайд/үрээр/тарьсан.

ХАМГААЛАЛТЫН ЗУРВАС БАЙГУУЛАХ

Багануур ХК-ийн “Нэг сая мод” төслийн эхлэл болох 10000 ширхэг модыг 3.5 га талбайд тарьсан.

№	2022 онд тарьсан модны төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Улиас	385	385
2	Хайлаас	8000	8000
3	Гүйлс	1615	1615
	Нийт	10,000	10,000

2022 онд Байгаль орчны чиглэлээр үндсэн 3 ажлын байр бий болгосон. Мөн улирлын чанартай 12 ажилтанг гэрээгээр ажиллуулсан.

№	Мэргэжил	Орон тоо	Ажиллах хугацаа
1	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	1	Үндсэн
2	Байгаль орчны ажилтан	1	Үндсэн
3	Байгаль орчны туслах ажилтан	2	Үндсэн
4	Модны суулгац бойжуулалт, усалгаа арчилгаанд ажиллах гэрээт ажилтан	4	8 сар
5	Тарилтын үед ажиллах түр гэрээт ажилтан	8	3 сар /хавар, намар/
	Нийт	16	

6-р сард “Нэг сая мод” тарих зорилтын хүрээнд Багануур дүүрэгтэй хил залгаа Төв аймгийн Баяндэлгэр, Архуст, Мөнгөнморьт, Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Цэнхэрмандал, Хэрлэнбаян-Улаан сумдын удирдлагуудтай уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар эдгээр сумдын нутаг дэвсгэрт мод тарих, ойжуулалт хийх, хамгаалалтын зурвас үүсгэх талаар санал солилцсон болно.



ХАМТЫН АЖИЛЛАГАА ГАДААД ХАРИЛЦАА



НУБ-ын дэлхийн эрүүл мэндийн байгууллагын номхон далайн баруун бүсийн захирал Такеши Касай тэгүүтэй зочид хүрэлцэн ирсэн. Багануур ХК-ийг Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний талаар туршлага болохуйц үр дүнд хүрсэн гэж дүгнэсэн.



Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Ёорн Розенберг тэргүүтэй зочид компанийн үйл ажиллагаатай танилцлаа. ХБНГУ-ын улсын нүүрсний уурхайнуудаас туршлага судлах, эдийн засгийн үр өгөөжтэй технологийн чиглэлээр болон нөхөн сэргээлтийн чиглэлээр хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцлоо.



Австрали Улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кэйти Смит, ЗГХЭГ-ын дэд дарга У.Бямбасүрэн, Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн захирал Л.Энхтүвшин мэргэжилтнүүдийн хамт зочиллоо. Австралийн засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломж, урт болон богино хугацаат сургалтын талаар компанийн удирдлагуудтай уулзлаа.



Япон Улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кобаяши Хироюки зочиллоо. “Багануур” ХК, Японы Комацу компанийн хамтын ажиллагаа 30 жилийн түүхтэй бөгөөд Монгол улсын эрчим хүчний хэрэгцээт нүүрсний 60 гаруй хувийг ханган ажиллахад тус брэндийн уул уурхайн тоног төхөөрөмжүүд асар их үүрэг гүйцэтгэсээр ирсэн билээ.

ОРОН НУТАГ

Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодексийг хэрэгжүүлэх харицан ойлголцлын санамж бичигт зааснаар Багануур дүүргийн Төр захиргааны байгууллага, “Багануур” ХК-ийн хоорондын хамтын ажиллагааны Санамж бичиг зурж, дүүрэгтэйгээ хамтран ажиллаж, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх тодорхой ажлуудыг зохион байгуулсан.

Дүүргийн Гал унтраах, аврах 64-р анги, Улаан загалмай нийгэмлэгийн Багануур салбар, ХАБЭА-н хэлтэстэй хамтран ГЭД, АУД хийлээ. Дасгал сургуулилт нь ажилтнуудад галын хор хөнөөл, гал гарахаас урьдчилан сэргийлэх, гал гарсан үед мэдээлэх, гарсан галыг унтраах, өөрийгөө болон бусдын эрүүл мэнд, эд хөрөнгө тоног төхөөрөмжийг хамгаалах арга барилд сургах зорилготой байдаг.

Гал эсэргүүцэх, аварь устгах, анхны тусламжийн дасгал сургуулилтад уурхайчин бүр тогтмол оролцож, энэ талын мэдлэг мэдээллээ дээшлүүлж байх нь болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

ОРОН НУТГААС АЖЛЫН ХУВЦАС ХУДАЛДАН АВАЛТ



УЛСАД ТӨЛСӨН
ТАТВАР
40,1
ТЭРБУМ



21657920	414264		
21215720	5498216		
326225		58742	
32255021			221233
1245755	32154316	3322144	
2154756	1245755	32366987	3221
320659	2154756		21258
221233	32659		
		121554	
214334	32147711	323150	32186664
5231		221550	232312
47512588	54715087		12789452
		326580	
		320125	332214
			323665



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.03.15 № 07/591
танай _____-ны № _____-Т

「 БАГАНУУР ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ТҮВШИНЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Багануур ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус компанийн тайлант хугацааны эцэст дансаар байвал зохих 3,234.8 сая төгрөгийн харилцагч байгууллагуудаас авах авлагын үлдэгдлийн дүнгийн талаар аудитын хангалттай ба зохистой нотолгоо авч чадаагүй. Иймээс бид уг дүнд ямар нэгэн залруулга хийх шаардлагатай эсэхийг тогтоох боломжгүй болсон.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй дараах алдаа, зөрчил нь тогтоосон 1,509.1 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд: Авлагын 3,234.8 сая, өглөгийн 9,407.3 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж 72.8 сая төгрөгийг зарцуулсан, ТБОНӨХБАҮХА тухай хуулийг зөрчиж 10,820.3 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг хийсэн.

Асуудлыг онцолсон хэсэг

Багануур ТӨХК нь Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон тайлант оноос хэрэгжиж эхэлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу Хамтын гэрээнд тайлант хугацаанд өөрчлөлт оруулаагүй байна. Тус компани ТӨБЗГ-ын 2022 оны 64 дүгээр тогтоолын дагуу хийгдсэн ТӨБЗГ-аас зохион байгуулагдсан үндсэн хөрөнгийн улсын тооллогод хамрагдсан байна.

2022-2023 оны өвлийн ачааллыг хүндрэлгүй даван туулах, ирэх оны үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Эрдэнэс таван толгой ХХК-тай 23,900.0 сая төгрөгийн зээлийн гэрээг байгуулж, тайлант онд 9,270.0 сая төгрөгийг хүлээн авсан.

Мөн түүнчлэн Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 588 дугаар тогтоолоор Эрчим хүчний зориулалтаар борлуулж буй 1 тонн нүүрсний үнийг нэмэгдүүлсэн ч энэ нь уурхайн хэвийн үйл ажиллагааг бүрэн ханган ажиллахад хангалттай дэмжлэг болж чадахгүй тул уг асуудлыг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн дээд байгууллагууд бодлогын хэмжээнд нэн яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна.

Аудитын гол асуудал

Багануур ТӨХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан бөгөөд нийт орлогыг 156,917.1 сая төгрөг, нийт зардлыг 197,641.1 сая төгрөг, 40,724 сая төгрөгийн цэвэр алдагдалтай ажиллахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 162,787.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 196,446.7 сая төгрөгийн зардал гарган, 33,659.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Багануур ТӨХК нь 2022 онд техник шинэчлэл, хөрөнгө оруулалтын чиглэлээр 9 багц арга хэмжээнд 16,842.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 13,824.1 сая төгрөгийн техникийн шинэчлэл, хөрөнгө оруулалтыг хийжээ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 82.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан


Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
			<i>/төгрөгөөр/</i>
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,050,042,808.71	3,982,323,532.05
1.1.2	Дансны авлага	8,775,365,449.82	10,010,013,841.16
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	371,175,156.89	739,531,557.44
1.1.4	Бусад авлага	64,240,000.00	74,240,000.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	32,943,858,583.54	45,001,906,854.70
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	9,323,479,731.94	10,839,246,771.63
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	52,528,161,730.90	70,647,262,356.98
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	176,950,745,513.87	151,858,946,967.51
1.2.2	Биет бус хөрөнгө	4,533,635,405.80	4,358,225,684.60
1.2.3	Уул уурхайн хөрөнгө/УУ хөгжүүлэлт, хөрс хуулалт/	27,750,619,346.40	27,209,712,833.10
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	999,767,331.34	999,767,331.34
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	764,393,387.00	764,393,387.00
1.2.10	Эрээлтийн бус хөрөнгийн дүн	210,999,160,984.41	186,191,046,203.55
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	263,527,322,715.31	255,838,308,560.53
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	41,551,861,528.33	52,405,529,509.13
2.1.1.2	Цалингийн өглөг	1,727,755,453.45	2,521,958,781.00
2.1.1.3	Татварын өр	36,418,069,735.09	48,087,404,572.38
2.1.1.4	НДШ - ийн өглөг	10,908,935,599.82	12,179,131,636.82
2.1.1.5	Богино хугацаат зээл	44,886,133,192.80	46,716,839,284.27
2.1.1.6	Хүүний өглөг	1,738,799,203.90	2,579,831,249.31
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	12,971,933.50	12,968,712.50
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,108,794,026.25	431,594,370.84
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	139,353,320,673.14	164,935,258,116.25
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	43,410,466,942.54	47,395,869,334.18
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	1,167,266,443.09
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	2,203,678,000.00	8,103,541,421.55
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	45,614,144,942.54	56,666,677,198.82
2.2	Өр төлбөрийн нийт дүн	184,967,465,615.68	221,601,935,315.07
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч - төрийн	1,573,077,000.00	1,573,077,000.00
2.3.2	хувийн	524,359,000.00	524,359,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	60,685,388,076.98	60,685,388,076.98
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	7,294,912,713.63	(28,546,450,831.52)
2.3.10	Тусгай зориулалтын нөөцийн сан	8,482,120,309.02	-
2.3.11	Эздийн өмчийн дүн	78,569,067,099.63	34,236,373,246.46
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	263,527,322,715.31	255,838,308,560.53

Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 он	2022 он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	152,292,931,653.25	160,262,944,907.10
2	Борлуулалтын өртөг	130,809,451,818.36	163,002,692,433.64
3	Нийт ашиг(алдагдал)	21,483,479,834.89	(2,739,747,526.54)
4	Түрээсийн орлого	17,478,212.26	20,563,400.00
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	4,164,713.64	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	356,523,350.84	782,792,383.66
9	Борлуулалт, маркетингийн зардал	669,139,400.01	567,136,179.19
10	Ерөнхий ба удирдлагын зардал	10,203,846,720.57	21,506,033,983.12
11	Санхүүгийн зардал	1,903,579,779.87	3,065,094,742.48
12	Бусад зардал	7,325,084,154.34	5,600,353,774.58
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	1,121,016,336.81	(984,174,801.56)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	164.48	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,881,012,558.13	(33,659,185,223.81)
19	Орлогын татварын зардал	1,370,853,622.56	25,020,000.01
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,510,158,935.57	(33,684,205,223.82)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,510,158,935.57	(33,684,205,223.82)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	1,510,158,935.57	(33,684,205,223.82)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-



Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Тусгай зориулалтын нөөцийн сан	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	9,657,130,648.58	7,672,308,688.50	80,112,263,414.06
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(1,175,010,339.54)	(1,887,554,910.44)	(3,062,565,249.98)
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	8,482,120,309.04	5,784,753,778.06	77,049,698,164.08
Өмчит гарсан өөрчлөлт					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				1,510,158,935.57	1,510,158,935.57
Зарласан ногдол ашиг					-
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	8,482,120,309.04	7,294,912,713.63	78,559,857,099.63
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(8,482,120,309.02)	-	(8,482,120,309.02)
Залруулсан үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	-	7,294,912,713.63	70,077,736,790.61
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(33,684,205,223.82)	(33,684,205,223.82)
Зарласан ногдол ашиг				-	-
Өмчид гарсан өөрчлөлт		-		(2,157,158,321.33)	(2,157,158,321.33)
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,097,436,000.00	60,685,388,076.98	-	(28,546,450,831.52)	34,236,373,245.46



Багануур ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
		/төгрөгөөр/	
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	151,077,689,218.70	161,237,556,096.93
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	150,672,159,365.77	160,957,619,734.73
	Буцаан авсан албан татвар	360,314,075.12	223,252,668.73
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	45,215,777.81	56,683,693.47
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	102,705,968,588.73	144,019,366,656.87
	Ажиллагчдад төлсөн	28,802,784,069.99	46,049,400,143.33
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,699,505,515.00	9,821,333,442.71
	Бараа материал худалдан авахад төлсөн	27,178,814,519.17	32,105,961,299.76
	Ашиглалтын зардалд төлсөн	-	-
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	27,208,909,872.76	39,813,145,427.81
	Хүүний төлбөрт төлсөн	132,499,856.16	132,547,301.21
	Татварын байгууллагад төлсөн	12,414,905,986.43	14,907,385,790.66
	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
	Бусад мөнгөн зарлага	1,268,548,769.22	1,189,593,251.39
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	48,371,720,629.97	17,218,189,440.06
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	39,354,044,407.07	14,294,679,711.54
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	39,320,980,360.07	14,250,000,664.54
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	33,064,047.00	44,679,047.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(39,354,044,407.07)	(14,294,679,711.54)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,222,474,434.00	31,273,553,657.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,222,474,434.00	31,273,553,657.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,893,299,263.16	31,268,648,788.97
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	10,893,299,263.16	31,268,648,788.97
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(8,670,824,829.16)	4,904,868.03
4	Валютын ханшийн зөрүү	(4,619.93)	3,866,126.79
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	346,846,773.81	2,932,280,723.34
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	703,196,034.90	1,050,042,808.71
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,050,042,808.71	3,982,323,532.05



ТЭМДЭГЛЭЛ



(976) – 7021 0114



www.baganuurmine.mn



**Улаанбаатар хот,
Багануур дүүрэг-12150,
3-р хороо, Багануур ХК**